

- Шүүхийн шинжилгээний албадад жолоочийн орон тоо батлагдаагүй тул алсын дуудлагад шинжээч бусад албан хаагчид авто машин жолоодох, батлагдсан шатахууны төсөв хүрэлцээгүй байгааг анхаарч шийдвэрлэх;

-Албан хаагчдыг мэргэшүүлэх, давтан сургах сургалтын зардал, төсвийг шийдвэрлэх.

*Ц.Мөнхбаяр -ХСИС, Хууль сахиулахын
удирдлагын академийн 8022-р дамжааны
суралцагч, цагдаагийн хошууч*

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН СУРГАЛТЫН ҮР НӨЛӨӨГДЭЭШЛҮҮЛЭХ нь

Хураангуй: Энэхүү илтгэлээр шүүхийн шинжилгээний байгууллагад язохион байгуулагдаж байгаа албаны болон мэргэжлийн сургалтын өнөөгийн байдал тулгамдсан асуудлуудыг судалж цаашид алба хаагч бүрт цаг үетэйгээ зэрэгцсэн, бодит үр нөлөө бүхий сургалт явуулах, сургалтын үйл явцыг боловсронгуй, хүртээмжтэй болгох боломжийг эрэлхийлсэн болно.

Түлхүүр үгс: “Шүүхийн шинжилгээ” гэж эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгч, прокурор, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид заасан тусгай мэдлэг шаардсан асуудал /шинжлэх ухаан, техник, урлаг, түүх, соёл, нягтлан бодох бүртгэл зэрэг/-ыг шийдвэрлэхийн тулд шинжилгээний объектод шинжилгээ хийж дүгнэлт гаргах ажиллагааг;

“**шинжээч**” гэж шүүхийн шинжилгээ хийж дүгнэлт гаргахаар хуульд заасан журмын дагуу томилогдсон, тусгай мэдлэг, мэргэжил эзэмшсэн этгээдийг;

“**шүүхийн шинжилгээний мэргэжилтэн**” гэж криминалистикийн болон эмнэлгийн тусгай мэдлэг, мэргэжил эзэмшсэн, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэргэжилтнээр оролцох эрх бүхий, шинжилгээний байгууллагын ажилтныг;

“**шинжээчийн дүгнэлт**” гэж шинжээч өөрийн тусгай мэдлэгийн хүрээнд хийсэн шинжилгээний явц, үр дүнг тусгасан нотлох баримтын эх сурвалж болох баримт бичгийг;

“**шинжилгээний магадлагаа**” гэж тусгай мэдлэг бүхий мөрдөгч ул мөр, эд мөрийн баримт болон хэргийн бусад материалд анхан шатны үзлэг оношилгоо хийж, үр дүнг тусгасан баримт бичгийг;¹

¹Шүүхийн шинжилгээний тухай хууль

“сургалт” гэж сургах үйлийн үр дүнг заасан нэр;

“сургалтын төв” гэж сургах үйлийн үр дүнг заасан нэр;

“хамтын ажиллагаа” гэж гадны болон дотоодын ямар нэг байгууллага, хүнтэй хамтран хийх хөдөлмөр, нэгдэж ажиллах явдал;¹

Хууль сахиулах үйл ажиллагаа гэдэг нь нийгмийн харилцааны сөрөг, муу үйл явдалуудын эсрэг чиглэж гэмт явдлуудын эсрэг тэмцэх, шудрага ёсыг тогтоодог хүн төрөлхтөний нийгэмшлийн үе шатад үүссэн нэгэн чухал ажиллагаа юм. Хүн төрөлхтөнд хуулийг сахиулж, зөрчсөн этгээдэд зохих хариуцлага хүлээлгэх ямарч ажиллагаа, тогтолцоо байддаггүй гэж төсөөлвөл хүн хүчтэй нь хүчгүйгээ дээрэлхэж араатан амьтнаас ялгарахгүй болно. Ингэхээр хууль сахиулах үйл ажиллагаа нь хүний нийгэмд ямар чухал хэсэг болох нь харагдаж байна.

Шүүхийн шинжилгээний байгууллага нь гэмт явдлын эсрэг шинжлэх ухааны үүднээс тэмцэх тархи нь юм. Шүүхийн шинжилгээний байгууллага нь бусад хууль сахиулах байгууллагуудаас ялгарах онцлог нь нийгмийн болон байгалийн шинжлэх ухаанд суурилан ажиллаж, шинжлэх ухааны нээлт, мэдээ мэдээллээс хоцрохгүй байх шаардлага зайлшгүй гарч ирдэг явдал юм.

Хувь алба хаагчийн шинжлэх ухаанч байдал нь үндсэн хоёр эх сурвалжаас бүрдэнэ. Үүнд:

1. Өөрийн хичээл зүтгэл, сониуч зан буюу хандлагаас
2. Сургалт, судалгаа мөн түүнийг хийх практик бололцооноос.*²

Нэгдүгээрт ангилсан алба хаагчдын “хичээл, зүтгэл, хандлага”-ыг ч мөн адил зөв зохион байгуулсан сургалтаар өдөөж, сайжруулах боломж бий. Энэ нь байгууллагын сургалтын асуудал хэр чухал болохыг харуулж байна.

Шүүхийн шинжилгээний байгууллагад сургалтын ажлууд тодорхой хэмжээнд явагддаг боловч мэдээ, мэдээлэл, шинжлэх ухаан, технологи хурдацтай хөгжиж буй энэ үед шинжлэх ухаанч байгууллагын ажилтан алба хаагч нарт дүйцэхүйц сургалтууд орж чадаж байна уу, бусад сургалт, сургуулиудад сурах боломж бололцоогоор хангаж чадаж байна уу гэсэн асуудлууд анхаарал татаж байна.

Шүүхийн шинжилгээний байгууллага нь алба хаагч, шинжээч, мэргэжилтний мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6 болон Шүүхийн шинжилгээний үндэсний төвийн дүрмийн 5.1.4-т заасны дагуу Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын 2013.10.22-ны өдрийн а\676 тушаалаар “Шүүхийн шинжилгээний байгууллагын алба

¹Монгол хэлний тайлбар толь, УБ 2010 он

²Багшийн гарын авлага, УБ. хот 2011 он МУБИС

хаагчийн сургалтын хөтөлбөр \2013-2018 он” болон Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын 2017.03.28-ны өдрийн а\04 тоот тушаалуудаар Шүүхийн шинжилгээний байгууллагын сургалтын журмыг батлаж гарган үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байгаа хэдий ч дээрх сургалт нь гагц хүү онолын сургалтууд явагддаг.

“Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн” гэх байгууллага нь Монгол улсын хууль, эрх зүйн орчинд чухал байр суурь эзэлдэг эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага юм.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн төв байранд криминалистикийн шинжилгээ, тусгай шинжилгээ болон шүүх эмнэлэгийн шинжилгээг төвлөрч хийдэг ба нийслэлийн бүх дүүргүүдэд криминалистикийн шинжилгээний тасгууд, аймгуудад шүүх шинжилгээний албад тухайн нутаг дэвсгэрийн үйл ажиллагааг хариуцан ажилладаг.

Дээрхээс үзэхэд шүүхийн шинжилгээний байгууллагад практик сургалт орхигдоход хүрч, цаашид нийслэл болон хөдөө орон нутагт ажиллаж байгаа криминалистикийн шинжээч мэргэжилтнүүд тэр дундаа шинээр сургууль төгссөж шинжээчээр томилогдон ажиллаж байгаа алба хаагчид нь зарим хэргийн газрын үзлэгт мэргэжилтнээр оролцоход хэргийн газрыг зөв үнэлэх, ул мөр, эд мөрийн баримтыг орхигдуулах, зарим ээдрээ төвөгтэй хэргийн шинжилгээ хийхэд мэргэжлийн туршлага, чадвар дутахад хүрч байна.

Энэ нь техник технологи хурдацтай хөгжиж, гэмт үйлдлийн арга, техник өөрчлөгдөн шинэ төрлийн хэргүүд үйлдэгдэж байгаа өнөө үед муу үр нөлөө үзүүлэх боломжтой. Жишээлбэл хувь шинжээч хар тамхины талаар сургалтад сууж байгаагүй, өмнө нь хар тамхийг нүдээр харж ч байгаагүй мөн энэ талаарх практик туршлага байхгүй хэрнээ хар тамхи хэрэглэсэн, зарж борлуулсан, хадгалсан гэх гэмт үйлдүүдийн хэргийн газарт мэргэжилтнээр оролцоход тухайн хэргийн газрын үзлэгийн үр дүнд муугаар нөлөөлж болзошгүй. Мөн тухайн хар тамхины эсрэг чиглэсэн үйл ажиллагаанд “мэргэжилтнээр оролцоно” гэдэг нь өөрөө учир дутагдалтай үйлдэл юм.

Иймээс шүүхийн шинжилгээний байгууллагын алба хаагчдад техник технологийн хөгжлийг таниулах, гэмт үйлдлийн арга, шинэ төрлийн хэргүүдийн тухай сургалт, мэдээллийг тогтмол, тухай бүрт зохион байгуулж байх хэрэгтэй. Үүний тулд байгууллагын хэмжээнд сургалтын асуудлыг нарийн зохион байгуулж, үр дүнтэй сургалтуудыг төлөвлөх, боловсруулах, хянах, үр дүнг тооцох сургалтын асуудлыг дангаар хариуцах нэгж хэрэгтэй гэж үзэж байна.

Шүүхийн шинжилгээний байгууллагын үйл ажиллагааг хэвийн, үр дүнтэй явуулах үндсэн чиглэл болно. Дээр дурьдсан болон бусад байгууллагын

бүтэц, үйл ажиллагаанаас үүдэн гарч буй сөрөг үр дагаварууд арилна. Сургалтын ажлыг байнга зөв зохион байгуулж ажилласнаар байгууллагын үйл ажиллагаа, байр суурь батжиж илүү шинжлэх ухаанч, шинжлэх ухааны үйл ажиллагаандаа төвлөрсөн үйл ажиллагаанууд хийхэд түлхэц болох юм.

Шинжлэх ухаанч байгууллагын төрийн алба хаагчдад чиглэсэн, тэр дундаа алба хаагчдын сургалт, сургалтын үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх нэг сэдэвт судалгаа шинжлэн магадлах ухааны болон хууль сахиулах үйл ажиллагааны бусад чиглэлээр магистр, докторын төвшинд хийсэн судалгаа, нийтлэл, өгүүлэл зэрэг нь хомс байгаа нь алба хаагчид энэ талын мэдлэгийг бие даан танин мэдэхэд хүндрэлтэй болгож байна.

Боловсрол судлалын чиглэлээр хийсэн судалгаануудаас үзэхэд нийтлэг сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, багшийн чанарыг дээшлүүлэх, сургалтын орчныг сайжруулах зэрэг үйл ажиллагаагаар сургалтад тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх гэж оролдсон байна.

Алба хаагчийн мэргэжлийн чадвар нь мэргэжлийн үйл ажиллагааны явцад байнга хөгжиж, баяжиж, баталгаажиж байдаг. Хүн өөрийгөө нийгмийн орчиндоо зохицуулан байнга тасралтгүй хөгжүүлж байх шаардлага гарч ирдэг. Иймээс ч Шүүхийн шинжилгээний байгууллага нь өөрийн үйл ажиллагааны зорилтдоо “Шинжээч мэргэжилтний мэдлэг боловсролыг байнга дээшлүүлж ур чадварыг ахиулах, дотоодын урт, богино хугацааны сургалтад хамруулж хөгжингүй орнуудын холбогдох сургууль, байгууллагуудтай хамтарч ажиллах” гэж тусгасан байдаг¹.

Өнөөдөр судлаачдын боловсруулан гаргасан онол, практикийн үнэтэй бүтээлүүдийг тэр бүр амьдрал дээр авч хэрэглэдэггүй, боловсролын үйл ажиллагааны халуун цэг дээр ажиллаж буй сурган хүмүүжүүлэгчид судалгааны шинжилгээний ажлуудыг судлан ололттой талуудыг нь пратикт ашиглах явдал нэлээд дутагдалтай байгааг дурьдах нь зөв байх.

Иймээс тус байгууллагын боловсролын чиглэлийн сургалтын орчны бүрдэлт, стандартыг тогтоож, үнэлгээг нь холбогдох мэргэжлийн байгууллагуудын оролцоотойгоор хийх шаардлагатай байна. Мөн манай улсад болон гадаадын оронд судлагдсан, хөндөгдөж байгаа асуудлуудыг судлан Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн алба хаагчдын давтан сургалт, сургалтын үр нөлөөг дээшлүүлэх чиглэлийн судалгаа хийж, асуудлыг шийдвэрлэхэд боловсролын чиглэлийн суурь судалгаа хангалттай хийгдсэн байна. Иймд шүүхийн шинжилгээний байгууллагын алба хаагчдын ажлын

¹. ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ ХӨТӨЛБӨР 2016-2021

болон мэргэжлийн онцлог, нөхцөл байдалд тааруулан үр нөлөө ихтэй сургалт явуулах, алба хаагчдыг байнгын сургаж сэдэлжүүлэх үйл явцыг шийдэх гарц гаргалгаа олох нь нэн шаардлагатай байна.

Дүгнэлт

Шүүхийн шинжилгээний байгууллагад практик сургалт дутмаг буйгаас шалтгаалж криминалистикийн шинжээч, мэргэжилтнүүд тэр дундаа шинээр сургууль төгсөж шинжээчээр томилогдон ажиллаж байгаа алба хаагчид нь зарим хэргийн газрын үзлэгт мэргэжилтнээр оролцоход хэргийн газрыг дутуу үнэлж, ул мөр, эд мөрийн баримтыг орхигдуулахад хүрч, зарим ээдрээ төвөгтэй шинжилгээ хийхэд мэргэжлийн туршлага, чадвар дутахад хүрч байна.

Шүүхийн шинжилгээний байгууллагын алба хаагчдад техник технологийн хөгжлийг таниулах, гэмт үйлдлийн арга, шинэ төрлийн хэргүүдийн тухай сургалт, мэдээллийг тогтмол, тухай бүрт хийж байх, сургалтын асуудлыг нарийн зохион байгуулах, үр дүнтэй сургалтуудыг төлөвлөх, боловсруулах, хянах, үр дүнг тооцох сургалтын асуудлыг дангаар хариуцан ажиллах нэгж хэрэгтэй гэж үзэж байна.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн алба хаагчдын давтан сургалт, сургалтын үр нөлөөг дээшлүүлэх чиглэлийн судалгаа хийж, асуудлыг шийдвэрлэхэд боловсролын чиглэлийн суурь судалгаа хангалттай хийгдсэн байна. Иймд шүүхийн шинжилгээний байгууллагын алба хаагчдын албаны болон мэргэжлийн онцлог, нөхцөл байдалд нийцүүлж үр нөлөөтэй сургалт зохион байгуулах, алба хаагчдыг байнгын сургаж сэдэлжүүлэх үйл явцыг шийдэх гарц гаргалгаа олох нь нэн шаардлагатай байна.